



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

Аймгийн шонхор цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Үндэсний их баяр наадмын Үндэсний бөхийн барилдааны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар Төрийн 2234, Их Монгол Улсын 819, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 36 жилийн ойн хүрээнд үндэсний бөхийн цол олгох 16 хүртэлх насны хүүхдийн барилдаанд дөрөв давж түрүүлсэн Говь-Алтай аймгийн харьяат Хантайшир дэвжээний бөх, Нямдоржийн Хангарьдад "АЙМГИЙН ШОНХОР" цол олгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД